



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/331

Өмнөдэлгэр сум

Мал, тэжээвэр амьтан, хашаа, худгийн
тооллогыг явуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 хэсэг, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дэх заалт, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, дэх заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/638 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэр дэх өмчийн бүх хэлбэрийн мал, тэжээвэр амьтан, хашаа худгийг тоолох ажлыг 2025 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 17-ны хооронд зохион байгуулсугай.

2.2025 оны жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Оюунгэрэл	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	С.Батсуурь	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн
Гишүүд:	Д.Наранчимэг	Наран багийн Засаг дарга
	Г.Эрдэнэсүвд	Баянзүрх багийн Засаг дарга
	А.Баянмөнх	Хэнтий багийн Засаг дарга
	М.Сод-Ирээдүй	Талынбулаг багийн Засаг дарга
	Э.Заяабаяр	Чандган багийн Засаг дарга
	С.Шижирбаатар	Төвийн багийн Засаг дарга
	Ж.Энххуяг	Гурванбаян тосгоны захирагч
	Х.Саруултуяа	Хөдөө аж ахуйн тасгийн дарга
	С.Гантогоо	Тархвар зүйч
	Д.Жамъяандорж	Сумын хэсгийн төлөөлөгч

3.Баг бүрт ажиллах ажлын хэсгийн ахлагч, тоологч, шивэгчдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

4.Мал тооллогод шаардагдах хөрөнгийг сумын Засаг даргын нөөц сангаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Баярмаа)-д зөвшөөрсүгэй.

5.2025 оны жилийн эцсийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж, багуудын ажлын хэсэгт мэргэшил, арга зүйн зөвлөмж өгч, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч бөгөөд ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунгэрэл)-д үүрэг болгосугай.



РЭНХТӨР

сумын Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 04-ний өдрийн
А/331 дугаар захирамжийн хавсралт

Жилийн эцсийн мал тооллогод ажиллах албан хаагчид

№	Нэрс	Баг	Ажлын үүрэг
1	Д.Наранчимэг	Наран	Ахлагч
2	Г.Мягмардорж		БИНХурлын дарга тоологч
3	Э.Батбаяр		Тоологч
4	Н.Мөнх-Эрдэнэ		Шивэгч
5	Т.Уянга		Шивэгч
6	Г.Эрдэнэсүвд	Баянзүрх	Ахлагч
7	Н. Ганбаатар		БИНХурлын дарга тоологч
8	Х.Цацралтуяа		Тоологч
9	Л.Баярмаа		Тоологч
10	Д.Баярхүү		Тоологч
11	С.Болдбаатар		Тоологч
12	Г.Мөнхзул		Шивэгч
13	Э.Ууганцэцэг		Шивэгч
14	О.Мөнгөнтуул	Хэнтий	Шивэгч
15	А. Баянмөнх		Ахлагч
16	Ц.Энхжаргал		БИНХурлын дарга тоологч
17	Т.Чинхуяг		Тоологч
18	Ё.Мөнх-Өлзий		Тоологч
19	Т.Эрдэнэтуяа		Тоологч
20	Х.Саруултуяа	Талын булаг	Шивэгч
20	Б.Ууганцэцэг		Шивэгч
21	М.Сод-Ирээдүй		Ахлагч
22	Б.Өлзийбаатар		БИНХурлын дарга тоологч
23	Т.Бэрцэцэг		Тоологч
24	С.Батсуурь	Чандган	Тоологч
25	Ц.Бямбасүрэн		Шивэгч
26	Э.Заяабаяр		Ахлагч
27	Ж.Мөнхжаргал		БИНХурлын дарга тоологч
28	С.Гантогоо		Тоологч
29	Д.Болортуяа		Шивэгч
30	Э.Цэвэг		Шивэгч
31	Т.Идэрсайхан		Шивэгч

32	С.Шижирбаатар	Төв	Ахлагч
33	Э.Баярбат		Тоологч
34	Б.Гантулга		Тоологч
35	Ш.Ганбаяр		Тоологч
36	С.Эрдэнэчимэг		Шивэгч
37	Г.Нарангарав		Шивэгч
38	Л.Оюунномин		Шивэгч
39	С.Одончимэг		Шивэгч